



БАТЛАВ:  
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЧЫН УҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

.....  
*Х.ТӨМӨРБААТАР*  
.....

УХД0072 9104399

**ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БИОЛОГИЙН ЛАБОРАТОРИЙН  
БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/гэрээний нэр: Шинжлэх ухааны сургуулийн биологийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер

Дугаар: МУИС/202004006

2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Монгол Улсын Их Сургууль** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос ОУХНУС-ийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэх-ийг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Цахим худалдан авах ажиллагааны систем** ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 40 минутанд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Үгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо,  
МУИС-ийн оюутны 5-р байр 06 тоот,  
Зохион байгуулагч Ц.Батсүрэн  
Холбоо барих утас: 75754400- /1213/**

Хоёр.

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарын үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарын хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (a) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцгоч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцгч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцгчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцгчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>• <i>Үнийн санал маягтын дагуу ирүүлэх,</i></li> <li>• <i>Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан маягтын дагуу ирүүлэх,</i></li> <li>• <i>Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх,</i></li> <li>• <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг ирүүлэх,</i></li> <li>• <i>Нийгмийн даатгалын ерөнхий газрын тодорхойлолт ирүүлэх,</i></li> <li>• <i>Нийлүүлэх барааны зураг, танилцуулгын хамт ирүүлэх,</i></li> <li>• <i>Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mn">www.e-tax.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй, өргүй байна,</i></li> <li>• <i>2018,2019 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайланг ирүүлнэ,</i></li> <li>• <i>Түргэн хөрвөх хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй байна,</i></li> <li>• <i>2018, 2019 он тус бүр хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын мэдээлэл /хийсэн ажлын гэрээ, актыг ирүүлэх/</i>,</li> <li>• <i>2018 ,2019 он тус бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй дүнтэй тэнцүү, түүнээс багагүй байна,</i></li> <li>• <i>Барааны чанарын баталгаат хугацаанд /12 сар/ засварлах, сэлбэх үйлчилгээ үзүүлэх тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл,</i></li> <li>• <i>Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч буй мэдэгдэл ирүүлнэ,</i></li> <li>• <i>Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлэх</i></li> <li>• <i>Тендерт оролцогчийг төлөөлөх этгээдэд олгосон итгэмжлэл,</i></li> </ul>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Монгол Улсын Их Сургууль</b>,  <b>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулгадаас байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн аж ахуйн изгэжийн цахим гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалыа цахим хэлбэрээр ирүүлнэ.</b>  <b>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр</b>  <b>Цаг: 10 цаг 00 минут</b></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Монгол Улсын Их Сургууль, Оюутны 5 дугаар байр</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>1 давхар 06 тоот</b></p> <p>Огноо: <b>2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 40 минут</b></p>

Дөрөв.

## Техникийн тодорхойлолт

Д/Д	Барааны нэр, төрөл	Техникийн үзүүлэлт	Тоо ширхэг	Зураг
1	<b>Микроскоп</b>	-2 нүдний дурантай, -дээд өсгөлт 1000x, -окуляр дуран WF10X/18mm, - объектив: Achromatic 4X,10X, 40X,100X(oil), -тавцангийн хэмжээ 135* 125 мм, 220в-р ажилладаг, -гэрэлтуулэг 20 вт галоген ламп	3	
2	<b>Усан бани</b>	-LED дэлгэцтэй, -2 секцтэй, -багтаамж 5л, - тэмп 99оС хүртэл халдаг, -нарийвчлал $\pm 0.5$ оC, -хүчин чадал 500вт	1	
3	<b>Лабораторийн халаагч тень</b>	-LED дэлгэцтэй, -2 секцтэй, -багтаамж 5л, - тэмп 99оС хүртэл халдаг, -нарийвчлал $\pm 0.5$ оC, -хүчин чадал 500вт	4	
4	<b>Тог баригч (дээрх багажинд)</b>	Хүчин чадал 1000-2500 ба түүнээс дээш батт Лабораторийн нарийн шинжилгээний төхөөрөмжүүдэд, болон бусад төхөөрөмжүүдэд тохиромжтой байх Дуу чимээ багатай	1	
5	<b>Лабораторийн хөргүүр</b>	-100л-ийн багтаамжтай, -40С градус дээр хөрс, -усны дээж хадгалах тохиргоо хийгдэх	1	
6	<b>Лабораторийн хөргөгч</b>	Нийт цэвэр багтаамж 554 литр; Хөлдөөгч цэвэр багтаамж 163 литр; Хөргүүрийн цэвэр багтаамж 391	1	
7	<b>Лабораторийн хөлдөөгч -80°C 2000 W, -10deg C to 86deg C, medium</b>	Лабораторийн хөлдөөгч -80°C, -хүчин чадалтай: 2000 W -температуур -10deg C to -86deg C, 80 литрийн - багтаамж: 2000 W -нэг хаалгатай, -температуур хянадаг дэлгэцтэй. загвар: medium DW-86L80	1	

8	<b>Хөргөгч ( Дээж, эм урвалж хадгалах )</b>	багтаамж:256 л -хөргүүр 181 л, хөлдөөгч 75 л, дуу чимээ 43 дБ, хэмжээ 60 x 64 x 167 см /өргөн х гүн х өндөр/, жин 62 кг	1	
9	<b>Ультрасоникатор (Ultrasonic bath)</b>	хэт авиа 40kHz, багтаамж 5 л	1	
10	<b>Аналитик жин Биотехнологийн нэгдсэн лабораториид</b>	Орчин үеийн загвартай, 160-310 гр даацтай, нарийвчлал 0.0001 гр, тавцангийн хэмжээ Ф90мм,	1	
11	<b>Колон тоологч</b>	Колон тоологч SC6 PLUS: Дохио дуугарч тоог баталгаажуулдаг, дундажаар 99 Петрийн аяганд анализ хийх боломжтой, тоолох хэмжээ: 0-999, LED дэлгэцтэй, петрийн аяганы хэмжээ: ø50, ø90мм эсвэл тохируулах боломжтой, компьютерт холбогддог, бактерийн эсрэг BioCote®-оор бүрхэгдсэн.	1	
12	<b>Спектрофотометр</b>	Үйлдвэрлэгч: Biobase Марк: BK-UV1600 Ø Долгионы урт: 190-1100мм Ø Зурvasын өргөн: 4 мм Ø Долгионы уртад нарийвчлал: ± 0,5 мм Ø Долгионы урт таарц: ≤ 0,3мм Ø Дуу чимээ: ± 0,0005A Ø Дэлгэц: 480*27265 мянган үнэн өнгөт TFT LCD Ø Фотометрийн горим: T, A, C, E Ø Фотометрийн хүрээ: 0 ~200%T, -0,301~3.0A	2	
	<b>Нийт</b>		18	

**ТАВ. БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо шир хэг	Хэм жих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Микроскоп	-2 нүдний дурантай, -дээд өсгөлт 1000x, -окуляр дуран WF10X/18mm, - объектив: Achromatic 4X,10X, 40X,100X(oil), -тавцангийн хэмжээ 135* 125 мм, 220в-р ажилладаг, -гэрэлтүүлэг 20 вт галоген ламп	3	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
Усан бани	-LED дэлгэцтэй, -2 секктэй, -багтаамж 5л, - темп 99оС хүртэл халдаг, -нарийвчлал ± 0.5 оC, -хүчин чадал 500вт	1	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
Лабораторийн халаагч тень	-LED дэлгэцтэй, -2 секктэй, -багтаамж 5л, - темп 99оС хүртэл халдаг, -нарийвчлал ± 0.5 оC, -хүчин чадал 500вт	4	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
Тог баригч (дээрх бағажинд)	Хүчин чадал 1000-2500 ба түүнээс дээш батт Лабораторийн нарийн шинжилгээний төхөөрөмжүүдэд, болон бусад төхөөрөмжүүдэд тохиромжтой байх Дуу чимээ багатай	1	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	

<b>Лабораторийн хөргүүр</b>	-100л-ийн багтаамжтай, -40С градус дээр хөрс, -усны дээж хадгалах тохииргоо хийгдэх	1	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
<b>Лабораторийн хөргөгч</b>	Нийт цэвэр багтаамж 554 литр; Хөлдөөгч цэвэр багтаамж 163 литр; Хөргүүрийн цэвэр багтаамж 391	1	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
<b>Лабораторийн хөлдөөгч -80°C 2000 W, -10deg C to 86deg C, medium</b>	Лабораторийн хөлдөөгч -80°C, -хүчин чадалтай: 2000 W -температур -10deg C to -86deg C, 80 литрийн -багтаамж: 2000 W -нэг хаалгатай, -температур хянадаг дэлгэцтэй. загвар: medium DW-86L80	1	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
<b>Хөргөгч (Дээж, эм урвалж хадгалах )</b>	багтаамж:256 л -хөргүүр 181 л, хөлдөөгч 75 л, дуу чимээ 43 дБ, хэмжээ 60 x 64 x 167 см /өргөн х гүн х өндөр/, жин 62 кг	1	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
<b>Ультрасоникат op (Ultrasonic bath)</b>	хэт авиа 40kHz, багтаамж 5 л	1	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
<b>Аналитик жин Биотехнологийн нэгдсэн лабораторид</b>	Орчин үеийн загвартай, 160-310 гр даацтай, нарийвчлал 0.0001 гр, тавцангийн хэмжээ Ф90мм,	1	ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	

<b>Колон тоологч</b>	Колон тоологч SC6 PLUS: Дохио дуугарч тоог баталгаажуулдаг, дундажаар 99 Петрийн аяганд анализ хийх боломжтой, тоолох хэмжээ: 0-999, LED дэлгэцтэй, петрийн аяганы хэмжээ: Ø50, Ø90мм эсвэл тохируулах боломжтой, компьютерт холбогддог, бактерийн эсрэг BioCote®-оор бүрхэгдсэн.	1	Ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
<b>Спектрофотометр</b>	Үйлдвэрлэгч: Biobase Марк: BK-UV1600 Ø Долгионы урт: 190-1100мм Ø Зурvasын өргөн: 4 мм Ø Долгионы уртад нарийвчлал: ± 0,5 мм Ø Долгионы урт таарц: ≤ 0,3мм Ø Дуу чимээ: ± 0,0005A Ø Дэлгэц: 480*27265 мянган үнэн өнгөт TFT LCD Ø Фотометрийн горим: T, A, C, E Ø Фотометрийн хүрээ: 0 ~200%T, -0,301~3.0A	2	Ш	Хичээлийн 2-р байр	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
		18					

Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**

**ҮНİЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон усгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## **2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч холбоо барих хаяг /утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээ эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад				

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | <b>1.1.</b> Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | <b>2.1.</b> Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | <b>3.1.</b> Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.   |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | <b>4.1.</b> Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br><b>4.2.</b> Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | <b>5.1.</b> Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй   |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | <b>6.1.</b> Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>            | <b>7.1.</b> Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.   |
|                                     | <b>7.2.</b> Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.  |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | <b>8.1.</b> Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |

- |   |  |
|---|--|
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>          | <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> |
| <b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b> | <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p>   |

## **B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- |   |   |
|---|---|
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>           | <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарын тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлох</b> | <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарын нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p>  |
| <b>13. Алданги</b>                          | <p>13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p>                                  |

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- |                          |   |
|--------------------------|---|
| <b>14. Ажил дуусгах</b>  | <p>14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.</p> |
| <b>15. Хүлээж авах</b>   | <p>15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.</p>   |
| <b>16. Эцсийн тооцоо</b> | <p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.</p>   |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дун нь гэрээний унийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлагы**

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлэгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сүүтгана.

**18. Гэрээг цуцлах**

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл

дусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар нь: <b>МУИС ШУС-ийн биологийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж МУИС/202004006</b>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <b>тавилга, эд хогшил нийлүүлэхээс бүрдэнэ.</b> Ажлын талбай нь <b>МУИС хичээлийн 2 дугаар байр</b>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр: <b>Гэрээ байгуулсан өдөр</b> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <b>Гэрээ байгуулсанаас хойши 30 өдрийн дотор</b>
<b>ГЕН 8.1</b>	<b>Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад эвдэрч, гэмтэхээс урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авч ажиллах ба тээвэрлэлтээс үүссэн хохиролыг бүрэн хариуцна.</b>
<b>ГЕН 11.1</b>	Гүйцэтгэлийн баталгаа <b>гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна.</b>
<b>ГЕН 12.1</b>	Даатгалын тусгай шаардлага: <b>Даатгалын бүх нөхцөлийг гүйцэтгэгч тал хариуцна.</b>
<b>ГЕН 13.1</b>	Алданги оногдуулах хувь: <b>Бараа нийлүүлж дуусгахаар төлөвлөгдсөн өдрөөс хойши хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний дүнгийн 0.1 хувиар алданги тооцно.</b> Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>10 хувиас хэтрэхгүй байна.</b> <b>Баталгаат засварын хугацаа нь: Багаж тоног төхөөрөмжийг актаар хүлээн авсан өдрөөс хойши 12 сар байна.</b>
<b>ГЕН 16</b>	Төлбөр хийх хугацаа: <b>Барааг 100% хүлээлгэн өгсөн, хүлээн авсан акт баримт, хурлын тэмдэглэл, чанарын баталгааг байришуулсан баримт зэргийг захиалагч талд хүлээлгэн өгсөнөөс хойши ажлын 5 хоног дотор гэрээний нийт дунтэй тэнцэх дунг нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ.</b>
<b>ГЕН 17.1</b>	<b>Aшиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг ажил хүлээлгэн өгөхдөө хамт хүргүүлнэ.</b> <b>Татвар, даатгалын төлбөрийг гүйцэтгэгч тал бүрэн хариуцана.</b>
<b>Маргааныг шийдвэрлэх (ГЕН-21.0)</b>	<b>Талуудын хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилийх замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.</b> <b>Зөвшилийлд хүрч чадаагүй тохиолдолд хуульд заасны дагуу шүүхээр шийдвэрлэнэ.</b>

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.  
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

## Ес.ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

**5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлон. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]